

“Монгол, Хятад, Оросын эдийн засгийн коридор”-ын хүрээн дэх Монгол Хятадын уул уурхай, эрчим хүчний хамтын ажиллагааны хэтийн төлөв

Б.Хөгжилт¹

Abstract: The prospect of China-Mongolian mine cooperation can be predicted through “China-Russia-Mongolia Economic Corridor” and “Northeast Asia Regional Perspective”. And briefly analyzes the mining cooperation between China and Mongolia. China-Mongolian mine energy cooperation is already established in the two countries focus on economic and trade areas. In addition to substantial growth in trade, investment cooperation has always been unsatisfactory. The development of “China-Russia-Mongolia Economic Corridor” has given new connotation to the cooperation between China and Mongolia. Further cooperation with Russia will provide convenient conditions for policies, facilities and funds.

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд Монгол, Хятадын уул уурхай, эрчим хүчний хамтын ажиллагааны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр “Монгол, Хятад, Оросын эдийн засгийн коридор”-ын болон Зүүн Хойд Азийн бүс нутгийн хараасаас Монгол, Хятадын уул уурхай, эрчим хүчний хамтын ажиллагааны хэтийн төлөвд дүгнэлт хийхийг хичээсэн юм. Монгол, Хятадын уул уурхай, эрчим хүчний хамтын ажиллагаа бол хоёр орны хооронд тогтоосон худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны голлох салбар болно. Тус салбарын хамтын ажиллагааны хөгжлийн үйл явцад хэдийгээр хоёр талын худалдаа арилжааны хэмжээ ихээр өссөн ч хөрөнгө оруулалтын, ялангуяа томоохон төслийн хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа тийм ч ханамжтай бус байсаар ирэв. “Монгол, Хятад, Оросын эдийн засгийн коридор” байгуулах тохиролцоо болон түүний ахиц нь Монгол, Хятадын уул уурхай, эрчим хүчний хамтын ажиллагааг энэхүү хүрээнд хамруулан, түүнд шинэ агуулга нэмэрлэхээр үл барам Оросын талын ижил чиглэлийн нийлмэл хүч нэмэгдэж, тус салбарын хамтын ажиллагааны цар хүрээ, түвшин өндөржихэд, бодлого, дэд бүтэц, хөрөнгийн уялдаа холбоог хялбарчлах нөхцлийг хангах болно.

Түлхүүр үг: Монгол, Хятад, Оросын эдийн засгийн коридор, Монгол Хятадын уул уурхай эрчим хүчний хамтын ажиллагаа, шинэ агуулга, хэтийн төлөв

¹ БНХАУ-ын ӨМИС-ийн Монгол Улс судлах төвийн дэд профессор

*Монгол Хятадын уул уурхай, эрчим хүчний
хамтын ажиллагааны хэтийн төлөв*

Монгол, Хятадын уул уурхай, эрчим хүчний хамтын ажиллагаа бол хоёр орны хооронд тогтоосон худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны голлох салбар болно. Тус салбарын хамтын ажиллагааны хөгжлийн үйл явцаас үзэхэд, хэдийгээр арилжааны хэмжээ ихээр өсөн нэмэгдсэн ч хөрөнгө оруулалтын, ялангуяа томоохон төслийн хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа тийм ч ханамжтай бус байсаар ирэв. Энэ нь улс хоорондох эдийн засгийн хамтын ажиллагаанд эдийн засгийн бус хүчин зүйлүүдийн нөлөөллөөс голчлон шалтгаалж байна.

Нэг. Монгол Хятадын уул уурхай, эрчим хүчний хамтын ажиллагааны өнөөгийн байдал

1. Монгол Хятадын уул уурхай, эрчим хүчний бүтээгдэхүүн худалдаа

2015 оны Монгол Хятадын худалдаа² 5.26 тэрбум ам.доллар байсан нь Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлтийн 62%-г эзлэнэ. Үүнд экспорт 3.9 тэрбум ам.доллар байсан нь Монгол Улсын нийт экспортын 83.5%-г эзэлж, сүүлийн 6 жилийн доод түвшинд хүрсэн нь уул уурхай, эрчим хүчний бүтээгдэхүүний үнийн бууралт нөлөөлсөнтэй холбоотой. Нүүрс, зэсийн баяжмал, молибдений баяжмал, жонш, төмрийн хүдэр, цайрийн баяжмал, түүхий газрын тос зэрэг 7 нэр төрлөөр голлосон уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нийт экспортын 78.8%-г эзэлж, түүхэн хамгийн өндөр хэмжээнээсээ 10 гаруй хувиар буурсан (Зураг 1-ийг үзнэ үү) байна. Тэдгээр бүтээгдэхүүний 90% гаруйг нь Хятадад экспортолжээ. Тодруулбал нүүрсний 96.8%, зэсийн баяжмалын 99.3%, молибдений баяжмалын 72.8%, жоншны 41.8%, төмрийн хүдрийн 89.5%, түүхий газрын тос болон цайрын баяжмал 100% тус тус Хятадад гарчээ. Энэ нь Монгол Улсын экспортын бараа бүтээгдэхүүн нь уул уурхайн цөөн нэр төрлөөр голлох, Хятадын зах зээлээс хэт хамааралтай байх, олон улсын зах зээлийн үнийн хэлбэлжилд хүчтэй нөлөөлөгддөг болохыг харуулж байна. Импорт 1.36 тэрбум ам.доллар байсан нь Монгол Улсын нийт импортын 35.8%-г эзэлж, түүхэн шинэ түвшинд хүрсэн нь цахилгаан

2 Монгол Улсын Гаалийн ерөнхий газар, “2015 оны 12-р сарын гадаад худалдааны статистик мэдээлэл”, Online Statistic Information System <http://customs.gov.mn/>

эрчим хүчний импортын өсөлт³-өөс голлон шалтгаалжээ.



Эх сурвалж: Гадаад худалдааны жилийн нийт эргэлт, экспорт, импорт, жилээр
<http://www.1212.mn/statHtml/>

Хятад нь 1999 онд Монгол Улсын худалдааны хамгийн том түнш орон болсноос хойш Монголын экспорт, импортод эзлэх хувь, ялангуяа экспортод эзлэх хувь нь эрс нэмэгдэж, сүүлийн жилүүдэд 83%-92%-ийн хооронд хэлбэлжиж байна. (хүснэгт 1-ээс харна уу.)

Хүснэгт 1: Монгол Улсын экспорт, импортод Хятадын эзлэх хэмжээ, хувь

Он	Хятадад		Хятадаас	
	Экспорт, сая ам.доллар	Нийт экспортод эзлэх хувь%	Импорт, сая ам.доллар	Нийт импортод эзлэх хувь%
2005	512.4	48.1	291.0	24.7
2006	1046.5	67.9	353.8	24.7
2007	1406.9	72.2	664.7	32.2
2008	1633.8	64.5	888.0	27.4
2009	1392.3	73.8	531.7	24.9
2010	2454.4	84.4	956.4	29.9
2011	4404.6	91.4	1978.2	30.0

3 2015 онд цахилгааны үнийн 86%-г Хятадаас импортолжээ.

*Монгол Хятадын уул уурхай, эрчим хүчний
хамтын ажиллагааны хэтийн төлөв*

2012	4028.5	91.9	1842.5	27.3
2013	3700.3	86.7	1785.8	28.1
2014	50.7	87.8		33.1

*Эх сурвалж: Монгол Улсын Гаалийн ерөнхий газар,
“2014 оны 12-р сарын гадаад худалдааны тойм”*

2. Монголын уул уурхайн салбар дах Хятадын хөрөнгө оруулалт

Хятадаас Монголын уул уурхайн салбарт хөрөнгө оруулах нөхцөл нь бусад улс орныхоос газар зүйн байршил болон эдийн засгийн нөхвөрлөх байдал, хүмүүнлэгийн давуу талтай байж, 1998 онд Монгол Улсын хамгийн их хөрөнгө оруулалтын улс болсон байр сууриа эдүгээ хүртэл хадгалсаар байна.

Монгол банкны болон Хөрөнгө оруулалтын газрын тоо баримтыг үндэслэвэл, 1990-2015 оны хооронд нийт гадаадын шууд хөрөнгө оруулалт 16.753 тэрбум ам.доллар, түүний 72.5% нь уул уурхайн салбарт орсон бөгөөд мөн хугацаан дах Хятадын шууд хөрөнгө оруулалт 4.34 тэрбум ам.доллар байж, нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 25.9%-г эзлэж байна.⁴ Хятадын хөрөнгө оруулалт 2011 онд 1 тэрбум ам.доллар байсан юм. Хэдийгээр 2015 онд 106 сая ам.доллар болж буурсан ч энэ нь Хонгконгийн дараах хоёрдугаар байрт орох үзүүлэлт юм.

Монгол Улсын Ашигт малтмалын газрын тоо баримтыг үндэслэвэл, 2015 оны эцэс хүртэлх хугацаанд, Хятадын 100%-ийн хөрөнгө оруулалттай буюу хамтарсан 201 аж ахуйн нэгж 299 ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. Үүнд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт 2010 оноос хойш, Их Британийн Виржиний арлуудаар голлож, байгаа бол Хятад нь 2, 3, 4-р байрт орж байна (хүснэгт 2-ийг үзнэ үү). Үүнээс төсөөлөхөд, сүүлийн жилүүдэд Хятадын тус салбар дахь хөрөнгө оруулалтын хувийн жин нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын дундаж хэмжээнээс бага байх төлөвтэй.

⁴ Монголбанкны нийтэлсэн тоо баримтыг үндэслэн тооцоолов.

**Хүснэгт 2: Монгол Улсын олборлох салбарын хөрөнгө
оруулалт нэгж: тэрбум төгрөг**

Улс	2011		2012		2013		2014	
Нийт	3737.4	100%	3945.8	100%	4810.1	100%	5925.2	100%
Монгол	56.2	1.5%	83.3	2.1%	98.8	2.1%	794	13%
Малайз	1.0	0.0%	2.6	0.1%	0.4	0.0%	303.3	5%
Монгол-Солонгос	-	-	3.3	0.1%	-	-		
Монгол-Хятад	-	-	1.2	0.0%	-	-		
АНУ	0.3	0.0%	-	-	9.7	0.2%		
Болгар	0.4	0.0%	0.5	0.0%	0.6	0.0%		
Монгол-Виржиний арлууд	3651.0	97.7%	3518.51	89.2%	4578.8	95.2%	4166.34	70%
Герман	7.6	0.2%	-	-	-	-		
Канад	-	-	-	-	1.2	0.0%		
Кайманы арлууд	7.6	0.2%	65.0	1.6%	11.6	0.2%		
ОХУ	3.5	0.1%	167.6	4.2%	0.5	0.0%		
БНХАУ	9.4	0.3%	103.6	2.6%	108.5	2.3%	600	10%
Япон	0.2	0.0%	-	-	-	-		
Чех	0.2	0.0%	0.2	0.0%	0.019	-		

Эх сурвалж: Монгол Улсын Ашигт малтмалын газар, Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн тайлангийн эмхэтгэл

Хоёр. “Монгол, Хятад, Оросын эдийн засгийн коридор”-оос Монгол Хятадын уул уурхай, эрчим хүчний хамтын ажиллагаанд нэмэрлэсэн шинэ агуулга

“Монгол, Хятад, Оросын эдийн засгийн коридор” бол Хятадын “Торгоны замын эдийн засгийн бүс”, Монголын “Талын зам”, Оросын “Евразийн эдийн засгийн холбоо” санаачлагыг харилцан уялдуулах тохиролцоо болно. Гурван орны төрийн тэргүүн нар 3 дахь удаагийнхаа уулзалтаар энэхүү эдийн засгийн коридор байгуулах төлөвлөгөөний хөтөлбөрт гарын үсэг зурсан юм.

Хятадын дэвшүүлсэн “Торгоны замын эдийн засгийн бүс” санаачлага нь нээлттэй хамтын ажиллагаа, эе зохицол хүлцэлтэй, зах зээлийн жамаар харилцан ашигтай хамтдаа хожих хамтран байгуулах

*Монгол Хятадын уул уурхай, эрчим хүчний
хамтын ажиллагааны хэтийн төлөв*

зарчмаар бодлого, дэд бүтэц, худалдаа, хөрөнгө санхүү, ард иргэдийн сэтгэлийн уялдаа нэгтгэлийг бий болгох гэсэн, том орон зайн үе шаттай ахин дэвших бүс нутгийн хамтын ажиллагааны загвар мөн⁵. Монголын дэвшүүлсэн “Талын зам” санаачлага бол төмөр зам, хурдны автозам, газрын тос болон байгалийн хий дамжуулах хоолой, өндөр хүчдэлийн цахилгаан шугмаар Хятад, Оросыг холбох дэд бүтцийн дамжин өнгөрөх, зангилааны чадавхыг голлосон загвар юм⁶. Харин Оросын дэвшүүлсэн “Евразийн эдийн засгийн холбоо” бол “ЗХУ-ын дараах орон зай” дахь тогтолцооны зохицуулалтын загвар байна.

“Монгол, Хятад, Оросын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр” нь Хятадын дэвшүүлсэн зургаан коридорын анх үзэглэн тогтоосон төсөл болохынхоо хувьд, түүний ач холбогдол маш их байх нь мэдээж юм.

“Монгол, Хятад, Оросын эдийн засгийн коридор” байгуулах тохиролцоо болон түүний хэрэгжилт нь Монгол, Хятадын уул уурхай, эрчим хүчний хамтын ажиллагааг энэхүү хүрээнд хамруулж, түүний цар хүрээ, түвшин өндөржхөд бодлого, дэд бүтэц, хөрөнгө санхүүжилтийг хялбарчлах нөхцөл хангахын зэрэгцээ, шинэ агуулгаар баяжуулсан байна. Тэр нь “илүү дотно, чин сэтгэлээсээ, харилцан ашигтай, хүртээмжтэй байх” хөршийн ойлголт болон Монголын амин чухал эрх ашгийг харгалзах зарчим, Монголын хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хууль тогтоомж болон шинэчлэлийн чиг хандлагын дагуу, хамтын ажиллагаанд үүсэн буй болсон асуудал, сорилтуудыг нухацтай дүгнэж, “эдийн засгийн коридор” болон илүү өргөн хараасаас хамтын ажиллагааны зам, арга загварыг эрэлхийлэн судлах; Монгол Улсын нөөц баялагийн ашиглалт, экологийн хамгаалалт, усны нөөцийн зохицуулалт, ард олны амьжиргаа, сайн сайхны хүрээнд том төсөл, дэд бүтэц, банк санхүүгийн хамтын ажиллагаа өрнүүлэх; Монгол Улсын Хятад-Орос хоорондох, Евразийн дамжин өнгөрөх зангилаа бүс болох чадварын бүтээн байгуулалтыг дэмжих; Монгол Улсын уул уурхай эрчим хүчний бүтээгдэхүүний хоёр дахь зах зээлд оролцох эрэмжлэлийг зүй зохистой хангах; Оросын ижил чиглэлийн нийлмэл хүчний идэвх хүчин зүйлийг дайчлах зэрэг болно.

5 《推动共建丝绸之路经济带和21世纪海上丝绸之路的愿景与行动》全文-闽南网
<http://www.mnw.cn/news/china/878066.html>

6 仅一条铁路口岸输华 蒙古亟待打通“草原之路”_国际先驱导报_《参考消息》官方网站
http://www.guancha.cn/Neighbors/2015_07_10

Гурав. Хятад Монголын уул уурхай, эрчим хүчний хамтын ажиллагааны хэтийн төлөв

Хэдийгээр “Эдийн засгийн шинэ хэвийн байдал” доор Хятадын уул уурхай, эрчим хүчний эрэлт хэсэг хугацаанд саарсан ч Хятад нь тэдгээр бүтээгдэхүүнийг худалдан авах гол улс хэвээр бөгөөд дэлхийн эдийн засгийн чухал хөдөлгүүр болсоор байна. Монгол бол шинээр хөгжиж байгаа эрдэс баялгийн том орон боловч Хятадын зах зээлээс хараат юм. 2012 оноос олон улсын зах зээлийн үнийн уналтын мөчлөгийн улмаас сорилт бэрхшээлтэй учирсан тус улсын эдийн засаг нь бүс нутгийн нягт хамтын ажиллагааг улам ихээр шаардаж байна. “Парисын хэлэлцээр” батлагдсан нь сэргээгдэх эрчим хүчний эрэлтэд шинэ хандлагыг бий болгосноос гадна бүс нутгийн түвшинд нийлүүлэлт, эрэлт хэрэгцээний ашигтай тогтоцод нааштайгаар нөлөөлөх гурван орны коридор байгуулах тохиролцоо Монгол, Хятадын уул уурхай, эрчим хүчний хамтын ажиллагаанд шинэ агуулга нэмэрлэсэн зэрэг нь хоёр орны төдийгүй бүс нутгийн хамтын ажиллагаанд шинэ стратегийн боломжит хугацааг бий болгож байна.

1. Томоохон төслийн үйл явц түргэсэх.

Монголын уул уурхай, эрчим хүчний томоохон төсөлд оролцох гэсэн Хятадын аж ахуйн нэгжүүд саад бэрхшээлтэй учирдгийн гол шалтгаан нь нэг талаас Хятадын эдийн засгаас хараат болохоос болгоомжилсон Монголын талын эмзэглэл, нөгөө талаас Хятадын аж ахуйн нэгжүүдийн боловсронгуй бус бизнесийн ойлголт зэрэгтэй холбоотой. Монголын талын эмзэглэлийн гол үндэслэл нь “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д тогтоосон эдийн засагт аль нэгэн гадаад улсын оролцоо 30%-иас хэтэрч үл болох заалт юм. Зах зээлийн зарчимд “гуравдагч хөрш”-ийн бодлогыг нийцүүлэн хэрэгжүүлэх нь асуудал биш. Хятадын аж ахуйн нэгжүүдийн хувьд юуны өмнө дангаараа эзэмших буюу үнэмлэхүй хяналт тогтоох гэсэн сэтгэлгээгээ таягдах хэрэгтэй юм. Учир юун хэмээвээс тэрхүү хандлага нь Монголын хүчинтэй үйлчилж байгаа хууль, эрхзүйтэй зохицохгүй бөгөөд Монголын эдийн засгийн бие даасан байдал болон аюулгүй байдлын асуудлыг хөнддөг юм. Хамгийн боломжит хэлбэр нь Монголын талтай хамтарсан буюу гуравдагч этгээдийг багтаасан гурван талт хамтын ажиллагааны хэлбэр болохыг практик нотлож

*Монгол Хятадын уул уурхай, эрчим хүчний
хамтын ажиллагааны хэтийн төлөв*

байна. Хоёрт, Үндэсний аж үйлдвэрээ хөгжүүлэх гэсэн Монголын хүсэл эрэмзлэлийг харгалзан, боломжийн нөхцөлд үйлдвэрлэлийн гинжээ уртагтасан байх хэрэгтэй. Гуравт, “нутагшуулсан” менежментийн загварыг хэрэгжүүлж, нийгмийн хариуцлагаа чангатган, олон улсын аж ахуйн нэгжийн соёлыг нэвтрүүлсэн байх хэрэгтэй.

Коридор байгуулах явцад төр хувийн хэвшлийнхэн эдгээр тохиролцоо ойлголтыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлж чадвал томоохон төслүүд нь жижиг дунд төслөөс хавьгүй их ногдол ашгийг Монголын нийгэмд буй болгон, Монгол болон зарим хөрш орнуудад байдаг “Хятадын нөөц баялагийн аюулын үзэл”-ийг сааруулж, ард иргэдийн сэтгэлээс Засгийн газрын түвшин хэртэлх Хятадын хөгжлийн “галт тэрэг”-т дуртайяа суух хүсэл эрмэлзлэлийг нь нэмэгдүүлэх болно.

Нөгөө талаар, Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны олон улсын жишгээр томоохон төсөлд оролцох нь хоёр талт болон олон талт хамтын ажиллагааг ахиулах үр дүнтэй арга хэрэгсэл болно. Томоохон төслийн хэрэгжүүлэгч тал нь уг төслийг хэрэгжүүлэхэд хүчин чадлын хувьд хангалттай том аж ахуйн нэгж байх хэрэгтэй. Тийм байж л Монголын уул уурхайн ашиглалтын явцад учирч болзошгүй хөрөнгө оруулалт, байгаль орчны эрсдлээс зайлсхийж, Монгол Хятадын тус салбар дахь хамтын ажиллагаанд үлгэр жишээ үзүүлж чадах юм.

2. Нүүрс хийжүүлж, шингэрүүлэх болон нүүрс цахилгааны төсөл нь ойр дунд хугацааны хамтын ажиллагааны гол салбар мөн.

Монгол Улс нүүрсний нөөц ихтэй дэлхийн арван улсын тоонд багтдаг бөгөөд дийлэнх нь ил аргаар олборлоход зардал бага шаардагдах хүрэн нүүрсний ордууд болно. Тиймээс нүүрс хийжүүлж, шингэрүүлэх болон нүүрс цахилгааны, нүүрс химийн төсөл хэрэгжүүлэхэд тохиромжтой байдаг. Хоёр орны хооронд сүүлийн жилүүдэд хэлэлцэн тохиролцсон буюу дахин яригдах болсон төслүүд нь хамтын ажиллагааны энэхүү чиг хандлагыг харуулж байна.

2013 оны 10 дугаар сард Монгол Улсын Ерөнхий сайд Хятадад айлчлах үед Монголын тал “Синопек групп”-тэй жилд 15 тэрбум куб метр шатамхай хий үйлдвэрлэх хүчин чадал бүхий 30 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалттай нүүрс хийжүүлэх том төсөлд гарын

үсэг зурсан юм. Уг төсөл нь олон үе шатаар хэрэгжих бөгөөд бүтээн байгуулалтын хугацаанд 40 мянга, ашиглалтын хугацаанд 10 мянган ажлын байр буй болгоно⁷. Хэсэг хугацаанд зогсонги байдалд орсон тус төсөл 2015 оны 11 дүгээр сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хятадад хийсэн айлчлалын үеэр гаргасан хоёр талын хамтарсан мэдэгдэлд хэрэгжүүлэх төсөлд хамрагдсан юм.

Мөн айлчлалын үеэр “Шивээ-Овоо нүүрс цахилгааны төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн судалгааны ажлыг хамтран гүйцэтгэх тухай Хятадын Үндэсний цахилгаан дамжуулах сүлжээ корпораци болон Монгол Улсын Эрчим хүчний яам хоорондын гэрээ”-нд гарын үсэг зурав. Хэлэлцээрийн дагуу Хятадын “Үндэсний цахилгаан дамжуулах сүлжээ корпораци” нь хэрэгжүүлэгч гол нэгжийн хувиар жилд ил аргаар 34 сая тонн нүүрс олборлож, 14Ч660МВт суурилагдсан хүчин чадал бүхий цахилгаан станц хийгээд 8000МВт-ын ±800кВ-ын багтаамжтай тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугамыг байгуулах болно⁸.

Эдгээр том төслүүд болон тус салбарын бусад жижиг дунд төслүүд хэрэгжиж идэвхижиж эхэлсэн нь хоёр орны уул уурхай, эрчим хүчний хамтын ажиллагааны ойр дунд хугацааны гол суурь болохыг илтгэж байна.

3. Сэргээгдэх эрчим хүчний салбарын хамтын ажиллагаа нь хоёр орны тогтвортой хөгжлийн хэтийн төлөвийг зураглана.

Уул уурхайн хөгжлийн явцад үүссэн асуудал болон экологийн онцлогт суурилан Монгол Улс нь ногоон хөгжлийн стратегийг боловсруулж, нар, салхи зэрэг сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг 2020 он гэхэд эрчим хүчний хэрэглээнийхээ 20-25% хүргэх зорилт дэвшүүлсэн байна⁹.

Монгол Улсын нутаг дэвсгэрийн 71%-д салхны эрчим хүчийг ашиглаж болох бөгөөд суурилагдах хүчин чадал нь 1100кВ байна. 2013 онд Монголын цахилгаан эрчим хүчний хэрэглээний 5%-ийг

7 蒙缓步推进中蒙煤制气等大型能源项目—中华人民共和国驻蒙古国大使馆经济商务参赞处,

<http://mn.mofcom.gov.cn/article/jmxw/201405/20140500597103.shtml>

8 国网节能公司扎实推进中蒙锡伯敖包煤电输一体化项目前期工作 - 国家电网公司

<http://www.sgcc.com.cn/xwzx/gsxw/2015/11/330128.shtml>

9 2015-2020 年蒙古国的能源投资研究报告_新能源资讯_中国新能源网

<http://www.china-nengyuan.com/news/71296.html>

*Монгол Хятадын уул уурхай, эрчим хүчний
хамтын ажиллагааны хэтийн төлөв*

хангахуйц 40-170МВ-ийн хүчин чадалтай анхны салхин цахилгаан станц ашиглалтад оржээ. Үүнээс гадна Сайншанд зэрэг хэд хэдэн газарт салхин цахилгаан станц байгуулахаар төлөвлөж байна¹⁰.

Үүнээс гадна Монгол Улс нь нарны эрчим хүчний нөөцөөр маш баялаг, багцаагаар 5TWHW бөгөөд энэ нь дэлхийн хэмжээнд 3 дугаарт орох үзүүлэлт юм¹¹. Эдгээрээс үзэхэд, нар салхины эрчим хүчний ашиглалт нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн ирээдүйг тодорхойлохын зэрэгцээ гадаадын хөрөнгө оруулалтыг татах гол салбарын нэг болж байна.

Монголын сэргээгдэх эрчим хүчний ашиглалтын талаар дэвшүүлсэн төсөлд Японы “Азийн супер сүлжээ”, Монголын “Говийн бүсийн сэргээгдэх эрчим хүчний төсөл”, Хятад Солонгос Монголын “Говийн супер сүлжээ” зэрэг төлөвлөгөө бий¹². Эдгээрийн гурван талт төсөл нь харилцан ойлголцлын санамж бичиг байгуулжээ. Нар, салхины эрчим хүчний ашиглалтад, технолог, стандарт, хуулийн хязгаарлагдмал хүчин зүйл оршдог хэдий ч технологийн инноваци, бүс нутгийн интеграци, тогтвортой хөгжлийн чиг хандлага зэрэг нь түүний сайн сайхан ирээдүйг зураглаж байна.

4. Цахилгаан, дамжуулах хоолойн байгууламжийн бүтээн байгуулалтад хамтрах орон зай ихтэй.

Монголын эрчим хүчний асар их нөөц болон хамтын ажиллагааны өнөөгийн чиг хандлага нь ирээдүйд түүнийг Зүүн Хойд Азийн эрчим хүчний экспортын төв болгох хэтийн төлөвийг харуулж байна. Энэ нь Монгол, Хятадын болон бүс нутгийн хэмжээнд цахилгаан эрчим хүч, дамжуулах хоолойн систем буй болгохыг шаардаж байгаа юм. Одоогоор Монголын цахилгаан дамжуулах байгууламж нь дотоодын хэрэгцээгээ хангаж чадахгүй байна. Мөн Монголд газрын тос байгалийн хий дамжуулах хоолой үгүй. Монголын “Талын зам” санаачлагад 1100 км урттай өндөр хүчдэлийн шугам барих төлөвлөгөө бий. Монгол, Хятадын нүүрс хийжүүлэх болон нүүрс цахилгааны төслүүд нь дотоодын болон хоёр орныг холбосон агаарын шугам, дамжуулах хоолой тавихыг

10 2015年蒙古国际电力建设及新能源技术设备展会

<http://www.geo-show.com/ChannelHY/DL/Content/201412/37218.shtml>

11 2015-2020 年蒙古国的能源投资研究报告_新能源资讯_中国新能源网

<http://www.china-nengyuan.com/news/71296.html>

12 张琪. “风”从亚洲来|韩国| 济州岛.《瞭望东方周刊》. 2014 (17) _凤凰资讯

http://news.ifeng.com/a/20140505/40154782_0.shtml.

шаардах нь гарцаагүй. Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт Хятад, Оросыг холбох дамжуулах хоолойг Монголын нутгаар дайран өнгөрүүлэх техник эдийн засгийн үндэслэлийн судалгаа багтсан нь энэхүү шугам Монголоор дайран өнгөрөх боломжтойг харуулж байна. Монголын газрын тосны олборлолт зохих хэмжээнд хүрч нэмэгдвэл тэр нь зайлшгүй дамжуулах хоолой тавихыг шаардах юм. Энэ бүгдийн зэрэгцээ ирээдүйн сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг тооцоолбол, цахилгаан эрчим хүчний шугам болон газрын тос, байгалийн хий дамжуулах хоолойн бүтээн байгуулалт, түүнийг арчлан хамгаах ба ашиглах салбарын хамтын ажиллагааны боломж ихтэй байна.

5. Дэд бүтэц, боомтын бүтээн байгуулалт, усны нөөцийн зохицуулалт нь уул уурхай, эрчим хүчний хамтын ажиллагааны чухал туслах хөрөнгө оруулалтын чиглэл болно

Уул уурхай, эрчим хүчний үйлдвэрлэл, борлуулалт нь их хэмжээний дэд бүтцийг шаардана. Усны нөөцийн хомсдол болон дэд бүтцийн сул хөгжил нь Монголын уул уурхайн ашиглалтыг хязгаарлах хоёр хүчин зүйл болно хэмээн эрдэмтэд дурдаж байна.

2010 онд баталсан “Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого” болон 2014 оны 10 дугаар сард баталсан хоёр чиглэлд нарийн цариг тогтоосон нэмэлт өөрчлөлт нь эхлэлтийн шатандаа л байгаа билээ. Сүүлийн жилүүдэд Монгол, Хятад, Орос гурван орны төмөр замын хэлэлцээрээр Монголоор өнгөрөх тээврийн хэмжээг нэмэгдүүлэх тохиролцоонд хүрэв. Гэвч төмөр замын ачааллын хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Монгол, Хятадын хилийн 16 боомтын нэвтрүүлэх хүчин чадал нь худалдаа хөрөнгө оруулалтыг уялдуулан хэрэгжүүлэх шаардлагыг хангахгүй байна (ялангуяа Монголын талынх). Тэрчлэн Монголын уул уурхай, эрчим хүчний нөөц төвлөрсөн өмнөд бүсэд усны нөөц туйлын хомс билээ. Одоогоор гадаргын ус болон гүний усны ашиглалтын харьцаа 1:9 байгаа бөгөөд энэ нь нэгэнт усны эргэлтийн тэнцвэрийг ноцтой алдагдуулаад байгаа тул “Умардын усыг өмнөш татах” санал дэвшүүлсэн эрдэмтэд бий¹³. Гэвч үүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө асар их тул Монголын Засгийн газар дангаараа хэрэгжүүлэх боломж тун багатай. Эдийн

13 旭日夫，蒙中能源与交通领域合作关系，中国社科院亚太与全球战略研究院组办的“第五届中俄蒙三国论坛”会议论文，2014年6月13日；

*Монгол Хятадын уул уурхай, эрчим хүчний
хамтын ажиллагааны хэтийн төлөв*

засгийн коридор байгуулах хөтөлбөрт энэ талаарх олон төслийг жагсааж хамтран байгуулахаар болсон нь мөн энэхүү шаардлагыг харуулж байгаа юм. Эдгээр дэд бүтэцтэй холбогдох төслүүд нь Засгийн газрын эрх мэдлийн хүрээнд байх бөгөөд харин тэдгээрийг Засгийн газрын оролцоотойгоор аж ахуйн нэгжүүд хэрэгжүүлнэ. Ийнхүү дэд бүтэц, боомтын бүтээн байгуулалт, усны нөөцийн зохицуулалтын санхүүжилт хөрөнгө оруулалт нь уул уурхай, эрчим хүчний хамтын ажиллагаанд чухал туслах үүрэг бүхий хамтын ажиллагааны чиглэл болно.

Ер нь “Монгол, Хятад, Оросын эдийн засгийн коридор” нь нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх шатандаа оров. Эдийн засгийн коридор байгуулах тохиролцоо нь Монгол, Хятадын уул уурхай, эрчим хүчний хамтын ажиллагаанд шинэ агуулга нэмж, тус салбарын хамтын ажиллагаа шинэ стратегийн боломжит хугацаанд орсныг нотлон харуулж байна.

Ашигласан материал

1. 《推动共建丝绸之路经济带和21世纪海上丝绸之路的愿景与行动》全文-闽南网<http://www.mnw.cn/news/china/878066.html>
2. 仅一条铁路口岸输华蒙古亟待打通“草原之路”_国际先驱导报_《参考消息》官方网站http://www.guancha.cn/Neighbors/2015_07_10
3. Монгол Улсын Гаалийн ерөнхий газар, “2015 оны 12-р сарын гадаад худалдааны статистик мэдээлэл”, Online Statistic Information System, <http://customs.gov.mn/>
4. Монголбанк, Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позицийн статистик, https://mongolbank.mn/documents/statistic/externalsector/bopreview/bopreview_201504.pdf
5. Монгол Улсын Ашигт малтмалын газар, СТАТИСТИК МЭДЭЭ | investmongolia.gov.mn, http://investmongolia.com/?page_id=881
6. 蒙缓步推进中蒙煤制气等大型能源项目--中华人民共和国驻蒙古国大使馆经济商务参赞处, <http://mn.mofcom.gov.cn/article/jmxw/201405/20140500597103.shtml>

7. 国网节能公司扎实推进中蒙锡伯敖包煤电输一体化项目前期工作 - 国家电网公司,
<http://www.sgcc.com.cn/xwzx/gsxw/2015/11/330128.shtml>;
8. 2015-2020年蒙古国的能源投资研究报告_新能源资讯_中国新能源网 <http://www.china-nengyuan.com/news/71296.html>
9. 2015年蒙古国际电力建设及新能源技术设备展会,
<http://www.geo-show.com/ChannelHY/DL/Content/201412/37218.shtml>
10. 张琰. “风”从亚洲来|韩国|济州岛. 《瞭望东方周刊》. 2014 (17) _凤凰资讯;
http://news.ifeng.com/a/20140505/40154782_0.shtml.
11. 旭日夫, 蒙中能源与交通领域合作关系, 中国社科院亚太与全球战略研究院组办的“第五届中俄蒙三国论坛”会议论文, 2014年6月13日。